



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 04 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар Хэрг /596

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Л.БОЛД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийг сайжруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.БОЛДООС  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.ЭРДЭНЭБАТАД  
ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**НЭГ. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ  
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААР**

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлаас “Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2016 оны 69 дүгээр тогтоолыг баталсан. Энэ хүрээнд төсвийн тухай хууль тогтоомжийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр дараахь асуудлыг судалж, саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

**1. Бэлэглэлийн гэрээг ашиглан татвар төлөхөөс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлэглэлийн гэрээний бүртгэл болон бүртгэлийн байгууллага, нотариатын байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах:**

Засгийн газар татварын 2 дахь шатны шинэчлэлийг хийх ажлын хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслийг тус тус шинэчлэн боловсруулж байна. Эдгээр хуулийн төсөлд татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх ерөнхий дүрэм, мөн үнэ төлбөргүйгээр авсан бараа, ажил, үйлчилгээний орлогод албан татвар ногдуулах зохицуулалтыг тусгаж өгөхөөр төлөвлөж байна. Ингэснээр бэлэглэлийн гэрээг ашиглан татвар төлөхөөс зайлсхийх явдал буурах болно.

Нөгөөтэйгүүр, татварын алба, улсын бүртгэлийн алба хооронд шинээр бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тогтмол харилцан солилцож, боловсруулан, байнгын хяналт тавин ажиллаж байна.

**2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох:**

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохистой төвшинд хадгалах, татварын бааз суурийг тэлэх зорилгоор Засгийн газар дараах арга хэмжээг эхний ээлжид авч хэрэгжүүлэхээр холбогдох хуулийн төслийг боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогыг албан татвараас чөлөөлж байгааг 2017 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зогсоох. Өнгөрсөн хугацаанд иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогыг 2007-2016 онд буюу 10 жил албан татвараас чөлөөлсөөр ирсэн байдаг.

- Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн



хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины татварын хөнгөлөлтийг 50 хувиар бууруулах төсөл боловсруулав.

### **3. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх:**

Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт хийх сонирхол багатай буюу хийх сонирхол байхгүй болсон байгаа энэ үед Засгийн газраас итгэлийг сэргээх бодлого хэрэгжүүлж, түүнтэй холбогдсон хөрөнгө оруулагчдыг дэмжих, татах чиглэлээр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд бид хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчинд үнэлгээ хийж, зайлшгүй сайжруулах хууль, журам байгаа эсэх, ямар эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчлэл хийх шаардлагатай байгааг судалж байна.

Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж дахин хөрөнгө оруулах таатай улс болохын тулд юун түрүүнд бодлого, хууль, эрх зүйн тогтвортой орчинтой байх ёстойг гадаад, дотоодын бизнес эрхлэгчид нэгдсэн байдлаар сануулж байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль ерөнхий зохицуулалт бүхий хууль учир судалгааны үр дүнгээр баталж, нотлогдсон, үндэслэлтэй зарчмын саналын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь нийгэм, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулагчдад Хөрөнгө оруулалтын тухай хууль хэрхэн өөрчлөгдсөн гэдгээс урьтаж *“Монгол Улс хөрөнгө оруулалтын тухай хуулиа өөрчлөх гэж байна, өөрчилсөн”* талаарх мэдээлэл хүрэх эрсдэлтэй. Энэ нь хөрөнгө оруулалт хийхийг сонирхож байсан, төслийн санхүүжилт хийх гэж байсан хөрөнгө оруулагчдыг дахин хүлээлт, тандалтын нөхцөл байдалд оруулах өндөр эрсдэлтэй байна.

Тиймээс Засгийн газар, Үндэсний хөгжлийн газрын зүгээс Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацитай “Хөрөнгө оруулалтын бодлого, Хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийг хамтран хэрэгжүүлж, дараах шат дараалсан ажлуудыг хийж эхлүүлээд байна. Тухайлбал:

- Монгол Улсын Засгийн газрын бүтэц шинэчлэн өөрчлөгдөхөд Засгийг газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг шинээр байгуулах шийдвэрийг гаргасан. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор баталж, 2017 онд уг зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулсан. Үндэсний хөгжлийн газар нь хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хувьд зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаа бөгөөд Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран “Хөрөнгө оруулалтын бодлого, Хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн хүрээнд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн хөрөнгө оруулагчдын гомдол шийдвэрлэх механизмыг бий болгохоор хамтран ажиллаж байна.

- Мөн тус төслийн хүрээнд Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн орчин, нөхцөл байдал, хууль эрх зүй, бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, хөрөнгө оруулалтын стратеги, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал /ХОШЗ/ буюу Investment Reform Mapping хийх ажлыг эхлүүлээд байна. ХОШЗ боловсруулан гаргаснаар Хөрөнгө оруулалтын орчныг



урт, дунд хугацаанд сайжруулан шинэчлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин тогтвортой байх, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, шинээр болон дахин хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлэх, эерэг нөлөөллийг үүсгэх ач холбогдол бүхий "Хөрөнгө оруулалтын бодлогын мэдэгдэл" бодлогын баримт бичиг гарна.

Энэхүү баримт бичгийг боловсруулан гаргаснаар Монгол Улс Хөрөнгө оруулалтын бодлого, стратегитай болж, хөрөнгө оруулалтын орчин тогтворжиж, хууль, эрх зүйн орчин сайжирна гэж үзэж байна. Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглалыг боловсруулах ажлын хүрээнд Хөрөнгө оруулалтын хууль болон бусад бизнес, хөрөнгө оруулалттай холбоотой голлох хууль тогтоомжуудыг үнэлж дүгнэн уялдаа холбоог сайжруулах зөвлөмж гаргана.

#### **4. Төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгтэй давхацсан үйл ажиллагаа эрхэлдэг Засгийн газрын тусгай сангуудыг татан буулгах:**

Анх 2006 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль батлагдсанаас хойших Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах, давхардлыг арилгах зорилгод нийцүүлэн 2014-2016 онуудын төсвийг төлөвлөхдөө Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тухай бүр боловсруулж Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсны үр дүнд төсвөөс 100 хувь санхүүждэг болон дийлэнх санхүүжилтээ төсвөөс авдаг байсан 11 тусгай санг тэдгээрийн ажлын албадын хамт татан буулгасан

#### *"Засгийн газрын тусгай сангийн тухай" хуулийн дагуу татан буугдсан сангууд*

№	Сангийн нэр	Татан буугдсан хугацаа	
		2015 он	2017 он
1	Аялал жуулчлалын сан	татан буугдсан	
2	Дархлаажуулалтын сан	татан буугдсан	
3	Хүүхдийн төлөө сан	татан буугдсан	
4	Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан	татан буугдсан	
5	Эрүүл мэндийг дэмжих сан	татан буугдсан	
6	Сэргээгдэх эрчим хүчний сан	татан буугдсан	
7	Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сан	татан буугдсан	
8	Орон сууц хөгжүүлэх сан	татан буугдсан	
9	Хүний хөгжил сан		татан буугдсан
10	Цэвэр агаарын сан	татан буугдсан	
11	Инновацийн сан	татан буугдсан	



12	Цагдаагийн хөгжлийн сан	татан буугдсан	
13	Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан	татан буугдсан	
<b>НИЙТ ТОО</b>		<b>12</b>	<b>1</b>

Мөн УИХ-ын Төсвийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороогоор 2017 оны 1 дүгээр сард Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцээд 03 дугаартай тогтоол гаргасан бөгөөд үүгээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг даалгасан.

Үүний дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд орлогоороо зардлаа нөхөж бие даан ажиллах боломжтой сангуудад тусгай сангийн статус олгох, тэдгээрийн эх үүсвэр, зарцуулалтын зориулалтыг нарийвчлан тусгах, тусгай сангийн тоог цөөрүүлэх зарчмыг баримталж байна.

**5. Төсвийн шатлал бүрд төсвийн орлого, зарлагыг бодитой тооцох аргачлал бий болгох, төсвийн төслийг боловсруулахад баримтлах зарчмыг оновчтой тогтоох, хэлэлцэн батлах, төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах талаар бодлогын цогц арга хэмжээ авах:**

Тухайн жилийн төсвийн төслийг олон улсын хэмжээнд өргөн ашигладаг инфляци, валютын ханшийн өөрчлөлтөөр тохируулсан норм, нормативт суурилсан төсвийн суурь зардал болон хууль тогтоомж, эрх зүйн бусад актуудаар баталгаажсан шинээр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг хянан үзсэний үндсэн дээр боловсруулж байна.

Түүнчлэн зардлын үр ашгийг сайжруулах зорилгоор Төсвийн тухай хуульд заасны дагуу хөтөлбөр буюу эцсийн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төлөвлөлтөд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2014 оноос эхлэн хөтөлбөрт суурилсан төсвийн төсөл боловсруулах удирдамжийг жил бүрийн 6 дугаар сард багтаан Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлж байна.

Дэлхийн банкны тусламжтайгаар интернет орчинд суурилсан Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн шинэ систем (ТТМС)-ийг боловсруулан, 2017 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлд ашиглаж эхлээд байна. ТТМС нь бүх шатны төсвийн байгууллагууд интернет орчинд өөрсдийн төсвийг бэлтгэн, холбогдох дээд байгууллагуудаар хянуулан батлуулах, хуваарилах, цалин, гэрэл цахилгаан, халаалт гэх мэт анхан шатны тооцоолол, томъёо оруулах боломжтой систем юм. Системийг улсын болон орон нутгийн түвшинд бүрэн ашиглаж эхэлснээр улсын хэмжээний төсвийн нэгдсэн тоон мэдээ, мэдээллийг богино хугацаанд гаргах, мэдээллийн ил тод байдлыг хангах, шат шатны төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлд тавих бүх шатны хяналтын тогтолцоо сайжрах юм.



Дэлхийн банктай хамтран нэгдсэн төсвийн зарлагын өргөн хүрээг хамарсан шинжилгээг гүйцэтгэж байна. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн 2000 оноос хойшхи зардлыг төрөл, бүтцээр нь болон төсөвт нөлөөлж байгаа хүчин зүйлээр нь харьцуулан нийгмийн хамгаалал, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн салбар, түүнчлэн цалин хөлс, татаасны зарцуулалтад дүн шинжилгээ хийж байна.

Дүн шинжилгээний үр дүнг 2017 оны 6 дугаар сард Дэлхийн банкнаас ирүүлэх бөгөөд зөвлөмж, үр дүнг 2018 оны төсөвт тусган хэрэгжүүлэхээр тооцож байна.

Төрийн албаны тухай хууль болон салбарын хууль, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын гишүүний болон тэдгээрийн хамтарсан шийдвэрүүдээр төрийн албан хаагчийн нэмэгдлийг салбар бүрд харилцан адилгүй хувь хэмжээтэйгээр олгохоор /ихэвчлэн 1995-2000 онд батлагдсан/ шийдвэрлэснийг шинэчлэх, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс түүний бүрэлдэхүүнийг оновчтой тогтоох, төсвийн төлөвлөлтөд тусгах чиглэл баримталж байна.

Төрийн албан хаагчдад олгож буй нэмэгдлийг хууль тогтоомжоор тогтоосон төрөл, хувь хэмжээний хүрээнд шийдвэрлэж байгаа боловч эрх зүйн зарим актад тусгагдсан нэмэгдэл тогтоох дээд хэмжээг мөрдөөгүй хэтрүүлэх, ижил төрлийн албанд харилцан адилгүй хувь хэмжээ тогтоох, зарим төрлийн нэмэгдлийг давхардуулах, хууль тогтоомжид заагаагүй нэмэгдэл шинээр бий болгох зэрэг зөрчилтэй асуудлууд байна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлт болон энэ хуулийн холбогдох зүйл, заалтад төрийн албан хаагчид нэмэгдэл олгохтой холбоотой эрх зүйн актуудыг нийцүүлж, шинэчлэн тогтоох зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2017 оны 4 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

**6. Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг хянан үзэж, шинэчлэн батлах:**

Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал, орон нутгийн төсвийн төлөвлөлтөд хэрэглэх орцын норм, нормативыг шинэчлэх зорилгоор Сангийн сайдын тушаалаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд нийгмийн халамж асрамж, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хувьсах болон тогтмол шинжтэй зардлын орц болон эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх талаар гарсан хууль тогтоомж, эрх зүйн бусад актууд, холбогдох стандартуудыг нягталж өөрчлөлтийг аргачлалд тусган 2017 оны 2 улиралд шинэчлэн батлуулна. Ингэснээр 2018 оны төсвийн төсөл бэлтгэхэд уг шинэчилсэн аргачлалаар орон нутгийн төсвийг боловсруулах боломж нөхцөл бүрдэнэ.

**ХОЁР.ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**



## **1. Коксжих нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй нийцүүлэх, нэгдсэн нэг үнээр экспортод гаргах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх:**

Коксжих нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн төвшинтэй нийцүүлэхэд нүүрс боловсруулах үйлдвэрийг бүрэн ашиглах, гол худалдан авагч Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Засгийн газрын түвшинд ойлголцож, холбогдох гэрээ хэлэлцээг хийх, дэд бүтэц, тэр дундаа төмөр зам барьж ашиглалтад оруулах, боомтын үйл ажиллагааг сайжруулах шаардлага байна.

“Таван толгой”-н ордоос олборлосон нүүрсийг баяжуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэгдсэн “Нэг цонх”-ны бодлогоор экспортлох Засгийн газрын өгсөн үүргийн дагуу “Эрдэнэс Таван толгой” ХК нь “Энержи Ресурс” ХХК-ийн баяжуулах үйлдвэртэй хамтран ажиллах хувилбарыг судалж байна. Харин Нарийн сухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд экспортын нүүрсний үнийн нэг цонхны бодлого барьж ажиллах талаар Монгол Улсын Ерөнхий сайд албан томилолтын үеэр чиглэл өгсөн.

## **2. Түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах:**

Газрын тосны тухай хуулийн 45.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 104, 2016 оны 130 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/57 дугаар тушаалаар бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, тус компанийн толгой компани болох “Дачин Ойлфийлд” компани, “Дачин Ойлфийлд” компанийн толгой болох Хятадын үндэсний газрын тосны ашиглалтын корпорацийн төлөөлөлтэй уулзалт хийсэн. Уулзалтын үр дүнд хэлэлцсэн асуудлаар санамж бичиг байгуулахаар тохирсон. Манай тал санамж бичгийн төслийг боловсруулж, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д хүргүүлсэн. Үүний хариу болгож 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр нөгөө тал төсөлд саналаа ирүүлснийг өмнөх санамж бичгийн төсөлтэй харьцуулан судалж байна.

Мөн “Доншен газрын тос Монгол” компанитай байгуулсан гэрээний асуудлаар “Доншен” групп, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн удирдлагатай 2016 оны 12 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд уулзаж санал солилцсон. Уулзалтын үр дүнд хоёр тал уулзалтаар тохиролцсон асуудлаар протокол байгуулсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх хэлэлцээрийг 2017 оны 3 дугаар сарын 28-нд БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулсан.

## **ГУРАВ.ТӨСВИЙН ЗАРДАЛ ХЭМНЭХ АСУУДЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОН ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Төсвийн урсгал зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл цалин хөлс 25 хувь, бараа, үйлчилгээний бусад зардал 18.8 хувь, татаас, урсгал шилжүүлэг 34-36 хувь, зээлийн үйлчилгээний төлбөр 19.4 хувь гэсэн голлох бүрэлдэхүүнтэй байна.



Эдгээрээс нийт урсгал зардлын 18-19 орчим хувийг эзэлж байгаа бараа, үйлчилгээний бусад зардлыг сүүлийн жилүүдэд хэмнэлтийн горимд шилжүүлж бууруулах зарчмыг баримталж ирсэн. Тухайлбал, 2005 онд бараа, үйлчилгээний бусад зардлын нийт урсгал зардалд эзлэх хувь 2015 онд 40.6%, 2010 онд 23%, 2015 онд 19.1%, 2016 онд 21.2 %, 2017 онд 18.8 % болж буурсан байна.

Бараа, үйлчилгээний урсгал зардал дотор төрийн байгууллагуудын удирдлага, үйл ажиллагаатай шууд холбоотой дор дурдсан зардлуудыг тэвчиж болох буюу аливаа хууль тогтоомж өөрчлөхгүйгээр эрх бүхий байгууллагаас төсвийг бууруулж батлах, төсвийн зардлыг хэмнэх, захиргааны зардлыг бууруулах чиглэлээр бүх шатны төсвийн байгууллагад үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

*Зарим тэвчиж болох зардлын бууралт /сая төгрөг/*

Үзүүлэлт	2013	2014	2015	2016 Тод	2017 Бат	Зөрүү /2017- 13/	буурах хувь
	.1.	.2.	.3.	.4.	.5.	.6-1.	
<b>Нийт:</b>	<b>207,129.8</b>	<b>234,553.1</b>	<b>201,085.9</b>	<b>147,745.0</b>	<b>140,040.8</b>	<b>67,089.0</b>	<b>32%</b>
Бичиг хэрэг	11,001.2	11,681.3	8,939.1	7,028.4	8,164.4	2,836.7	26%
Тээвэр, шатахуун	46,305.9	45,459.1	40,179.2	39,001.6	37,356.3	8,949.6	19%
Шуудан, холбоо, интернет	10,386.6	12,040.7	10,994.9	9,668.0	9,853.8	-532.8	5%
Хог хаягдал зайлуулах, ариутгал	20,076.1	47,947.0	41,106.9	4,214.1	4,372.6	15,703.5	78%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,334.4	8,795.5	6,912.6	5,865.7	5,831.7	3,502.7	38%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,806.5	26,636.3	25,377.7	31,456.1	27,086.3	3,720.3	12%
Багаж, техник, хэрэгсэл	10,418.2	8,339.3	8,530.4	8,084.9	10,022.4	-395.8	4%
Тавилга	9,792.8	8,924.1	3,628.1	2,540.9	28.2	9,764.6	100%
Урсгал засвар	27,585.9	29,406.8	23,504.3	21,644	19,335	-	30%



				.8	.1	8,250.8	
Гадаад албан томилолт	16,568.1	14,355.8	11,492.4	4,938.7	5,879.7	10,688.5	65%
Дотоод албан томилолт	11,014.7	17,086.1	16,298.2	11,853.6	10,822.7	-192.0	2%
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,839.2	3,881.2	4,122.1	1,448.3	1,287.5	2,551.7	66%

Тухайлбал, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайдаас бусад байгууллага, албан тушаалтан гадаад томилолтын зардал гаргахгүй байх, албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс төлөхийг зогсоох, төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил, автомашин шинээр худалдан авахгүй байх, эмнэлэг, сургуулиас бусад төсвийн байгууллагад албан өрөө, ажлын байрны өрөө тасалгаанд урсгал засвар хийхгүй байх, эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, авлигатай тэмцэх байгууллага, хил хамгаалах болон хууль сахиулах зарим байгууллагаас бусад бүх шатны төсвийн байгууллагад албан ажлын хэрэгцээнд 1-ээс илүү автомашин хэрэглэхийг хориглох, төв суурин газарт шатахуун бага зарцуулалттай жижиг автомашин хэрэглэх журмыг мөрдүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

График. Зарим зардлын бууралт. 2013-2017 он /тэрбум төгрөг/



Ингэснээр бичиг хэрэг, тээвэр шатахуун, тавилга ба эд хогшил, нормын хувцас, урсгал засвар, гадаад дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зэрэг зардлуудыг 2013 оноос үе шаттайгаар бууруулсан ба 2017 оны анх батлагдсан түвшнийг 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 67.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Эмнэлэг, онцгой байдлын алба, хил хамгаалах, хууль сахиулах байгууллагуудаас бусад төсвийн байгууллагуудын тээвэр шатахуун, урсгал



засвар, тавилга эд хогшил, гадаад албан томилолтын зардал зэргийг 2013 оны түвшнээс 20-65 хувиар бууруулсан байна.

Цаашид эдийн засгийн хямралаас гарах хүртэл хугацаанд төсвийн хэмнэлтийн горимыг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

**1. Төрийн албан хаагчдын тоог 2017 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байх:**

Төрийн албан хаагчийн нийт орон тоо 2005-2014 он хүртэл 124.9 мянгаас 180.0 мянга хүртэл нэмэгдсэн бол сүүлийн жилүүдэд төсвийн төлөвлөлтөд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх, төрийн албан хаагчийн орон тооны өсөлтийг хязгаарлах чиглэл баримталснаар өсөлт буурч байна.

Нийт төрийн албан хаагчийн орон тооны өсөлтийн 50 гаруй орчим хувь нь боловсрол, эрүүл мэндийн салбарт нэмэгдсэн бол 20 гаруй хувь нь хууль зүй болон шүүхийн салбарт нэмэгдсэн байна. Энэ нь хүн амд хүргэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээ өсөж байгаатай холбоотойгоор багш, эмч болон бусад үйлчилгээний орон тоо нэмэгдэж байгаа, мөн хууль болон шүүхийн салбарт эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг 2012-2016 онуудад хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор эдгээр салбарын орон тоо нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Бүтцийн хувьд улс төрийн албан хаагч 1.8 хувь, төрийн захиргааны албан хаагч 11.6 хувь, төрийн тусгай албан хаагч 20 орчим хувь, төрийн үйлчилгээний албан хаагчид 67 орчим хувийг эзэлж байна.

*Төрийн албан хаагчдын орон тоо, төрийн албан тушаалын ангиллаар*

	Нийт орон тоо	2017 он	Эзлэх хувь (%)	10000 хүнд ногдох төрийн албан хаагч
	<b>Нийт орон тоо</b>	<b>178857</b>	<b>100</b>	<b>585</b>
<b>1</b>	Улс төрийн албан хаагч	3271	1.8	11
<b>2</b>	Төрийн захиргааны албан хаагч	20753	11.6	68
<b>3</b>	Төрийн тусгай албаны албан хаагч	35033	19.6	115
<b>4</b>	Төрийн үйлчилгээний албан хаагч	119800	67.0	392
Үүнээс	Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан ажилтан	71224	39.8	233
	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний төрийн албан хаагч	25855	14.5	85
	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч болон гэрээт ажилтан	22721	12.7	74

Эх сурвалж: Сангийн яамны төсвийн мэдээллийн систем



Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан авч үзэх, төрийн албан хаагчийн албан тушаалын шатлал, зэрэглэл ахиулахыг 2017-2019 онд түр зогсоохоор тооцож Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголын төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Орон тооны хязгаарлалтын горимыг хэрэгжүүлэхдээ төрийн албан хаагчийг бүтцийн өөрчлөлтийн хүрээнд олноор халахгүй байх, 2017-2019 онуудад төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөөлөгдсөн бол дээрх хугацаанд нөхөн томилгоо хийхгүйгээр ажил, үүргийн хуваарийг шинэчлэх, оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, хэрэв зайлшгүй шаардлагатай орон тоог нөхөн томилох шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх замаар хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэв. Дээрх хугацаанд зөвхөн эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал, цагдаагийн албанаас хоёр албан хаагч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг албан хаагчийг (2:1) нөхөн томилох, бусад бүх салбарт нөхөн томилгоо хийхгүй байх зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

**2. Засгийн газрын тусгай сангуудын авлагыг барагдуулах, тусгай сан тус бүрийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг тооцох, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Тариаланг дэмжих сангийн хөрөнгийн бодит өгөөж, ажлын байр нэмэгдүүлсэн байдал, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний тоо хэмжээ, экспортод үзүүлсэн үр дүн, нөлөөллийн талаар судалгаа хийж, дүнг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулах:**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан тусгай сан бүрийн сүүлийн жилүүдийн орлого зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, хүрсэн үр дүнг зардлын өгөөжийн хамт тодорхойлохоор ажиллаж байна. Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолд заасны дагуу эргэлтийн сангийн зарчмаар ажилладаг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Тариаланг дэмжих сангийн хөрөнгийн бодит өгөөж, ажлын байр нэмэгдүүлсэн байдал, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний тоо хэмжээ, экспортод үзүүлсэн үр дүн, нөлөөллийн талаар судалгаа хийх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд дүнг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулахаар бэлтгэж байна.

**3. Гадаад зээллэгийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээл тус бүрийг үнэлэх, мөн зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй зээлүүдийг эргэн төлүүлж, үүссэн авлагыг барагдуулах:**

Монгол Улсын Засгийн газар 1990-2016 оны хооронд түнш орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас нийт 3.6 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг авч 210 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсэн. Үүнээс 1.5 тэрбум ам.долларын 92 төслийн зээлийн хөрөнгийг дотоодын 207 байгууллага, аж ахуй нэгжид дамжуулан зээлдүүлсэн.

*Зээлийн үлдэгдэл ба эргэн төлөлт*




Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 1,759.8 тэрбум төгрөг байна. Үүнээс 2017 онд төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого 38.4 тэрбум төгрөг бөгөөд 2017 оны эхний улирлын байдлаар 8.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

Санхүү, хөдөө аж ахуй, эрчим хүчний салбаруудад олгосон зээлийн эргэн төлөлт зээлийн гэрээнд заасан төлөвлөгөөнийхөө дагуу төлөгдөж байгаа бол бусад салбаруудад олгосон зээл, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн 2016 оны жилийн эцсийн үлдэгдлийг салбараар нь ангилан гадаад зээлтэй харьцуулан харвал нийт авсан гадаад зээлээс эдийн засгийн салбарт дамжуулан зээлдэх нь элбэг бөгөөд үүнээс эрчим хүч, зам, тээвэр, үйлдвэрийн салбарууд өндөр хувьтай байна. Харин нийгмийн салбарт гадаад зээлийн хөрөнгийг зарцуулдаг ч дамжуулан зээл олгох нь бага, орон сууц, нийтийн аж ахуйн салбарт дамжуулан зээлдэж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт дамжуулан зээл олгоогүй байна.

Гадаад зээл ба дамжуулан зээлийн харьцуулалт /салбараар/  
/тэрбум төгрөг/



Зээлийн үлдэгдэл болон 2017 оны төлбөрийн гүйцэтгэл

Үзүүлэлт	Үлдэгдэл 2016.12.31	Төлөвлөгөө 2017	Гүйцэтгэл 2017.3.31
<b>1. Эргэн төлөлт хийгдэж байгаа зээлүүд</b>	<b>638,104.02</b>	<b>25,148.73</b>	<b>8,730.34</b>
Жижиг, дунд үйлдвэрийн салбар	128,229.06	182.00	130.97
Зам, тээврийн салбар	7,825.84	462.21	
ОСНААҮ-ий салбар	18,064.35	671.27	
Санхүү, эдийн засгийн салбар	35,329.61	2,168.57	1,325.93
Хөдөө аж ахуйн салбар	104,867.95	1,087.65	1,467.81



Эрчим хүчний салбар	343,787.21	20,577.03	5,805.63
<b>2. Аймаг, нийслэлийн ЗДТГ-т олгосон зээл</b>	<b>330,809.80</b>	<b>645.70</b>	
Зам, тээврийн салбар	21,776.23		
ОСНААҮ-ий салбар	249,902.23		
Хөдөө аж ахуйн салбар	188.89		
Эрчим хүчний салбар	58,942.45	645.70	
<b>3. Эргэн төлөлт хийгддэггүй зээл</b>	<b>790,890.00</b>	<b>12,572.24</b>	
<b>3.1 Эргэн төлөлт хийгддэггүй</b>	<b>521,668.46</b>	<b>12,572.24</b>	
Зам, тээврийн хөгжлийн яам	249,677.98	2,119.51	
Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК	48,853.79	3,594.56	
Төрийн албан хаагчдад олгосон байр	234.05		
Төрийн Холбооны Газар	14,334.89		
УБ Төмөр Зам ХНН	116,412.11	6,858.17	
Эрчим Хүчний Газар	92,155.64		
<b>3.2 1991-1996 оны хооронд олгосон найдваргүй зээл</b>	<b>269,221.54</b>		
1991-1996 оны хооронд олгосон найдваргүй зээл	269,221.54		
<b>НИЙТ</b>	<b>1,759,803.83</b>	<b>38,366.67</b>	<b>8,730.34</b>

#### Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрийн удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2006 оны 185-р тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ыг шинэчлэн, Засгийн газрын гадаад зээллэгийн эх үүсвэрээс бүрдүүлсэн хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор гэрээний үндсэн дээр дамжуулан зээлдүүлэх, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, бүртгэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журмыг батлуулах;

- Дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг нарийн тооцоолол, төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлэх, эргэн төлөлт хийдэггүй аж ахуйн нэгж, байгууллагуудад олгох дамжуулан зээлийг хязгаарлах;

- Төсөвт байгууллагуудад дамжуулан зээлдүүлсэн эргэн төлөлт хийхгүй байгаа зарим зээлүүдийг тухайн байгууллагын төсөвт суулган төвлөрүүлэх, буцаан төлөлтийг хуваарийн дагуу хийлгэж төлөвлөгөөг таслахгүйн үүднээс улсын төсвөөс олгох хөрөнгө оруулалт болгон шилжүүлэх арга хэмжээг авах;



- Төсөвт болон төрийн өмчит зарим байгууллагын төрийн сан, арилжааны банкны орлогын данснаас боломжит нөхцөлийг судалсны үндсэн дээр дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрийг суутган авах;

- Эргэн төлөлт хийдэггүй 1990-2003 оны найдваргүй авлагуудыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

### **ДӨРӨВ.ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОН ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Төрийн өмчит компаниудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар баталгаажсан 10.8 их наяд төгрөгийн өр төлбөрийг бууруулах, зардлаа хэмнэх 2017 онд ашигтай ажиллах чиглэл өгч, хэрэгжилтийг нь хангах боломж, нөхцөл бүрдүүлэхийг зорьж байна. Түүнчлэн, төрийн өмчит компаниудын үйлдвэрлэл, санхүүгийн үр ашгийг өмнөх оноос дээшлүүлэх, авлага, өглөгийг бууруулах зарчмыг баримтлан 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хянаж баталсан болно. Ингэснээр 2015 онд 20 гаруй компани ашигтай ажиллаж байсан бол 2017 онд 70 гаруй компани ашигтай ажиллахаар төлөвлөгөөг батлав.

Өнгөрсөн 2016 оны сүүлийн 3 сард төрийн өмчит компаниудын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн хэмжээ нэмэгдсэн. Тухайлбал, “Монгол шуудан” ТӨХК нь 2015 онд 75.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2016 онд 1.2 тэрбум төгрөгийн ашигтай, “МИАТ” ХК нь 2015 онд 5.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2016 онд 11.0 тэрбум төгрөгийн ашигтай, “МЦХ” ХК нь 2015 онд алдагдалтай ажиллаж байсан бол 2016 онд ашигтай ажилласан байна.

Төрийн өмчит компаниудын 2016 оны балансын урьдчилсан дүнгээс харахад нийт орлогын хэмжээ нэмэгдэж, авлага, өр төлбөрийн хэмжээ буурсан. Богино хугацаат өр төлбөрийн хэмжээ төлөвлөснөөс 33.1 хувиар буюу 33.6 тэрбум төгрөгөөр буурсан. Түүнчлэн, “ТОСК”, “МИАТ”, “Хөдөө аж ахуйн бирж” зэрэг аж ахуйн нэгжүүдэд өрийн менежмент хийн ажиллаа. Улмаар “ТОСК”-ийн 100.0 гаруй тэрбум төгрөгийн өр төлбөрийн барагдуулаад байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төрийн өмчит компаниудын өр төлбөрийг бууруулах чиглэлээр компани тус бүр дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Засгийн газар төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, удирдлагын багийн хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, тайлагналыг ил тод, нээлттэй болгон хэвшүүлэх чиглэл баримтлан ажиллаж байна. Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн хуралд өгсөн удирдамж, чиглэлийг баримтлаагүй, хувийн ашиг сонирхлын үүднээс асуудалд хандсан эсвэл өгсөн удирдамж, чиглэлийг биелүүлэхгүй байгаа төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа ТУЗ-ийн дарга, гишүүдийг эргүүлэн татах чиглэл баримтлан ажиллаж байгаа бөгөөд эрчим хүчний болон авто замын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн ТУЗ-ийн нэр бүхий гишүүдийг эргүүлэн татсан. Хариуцлагын тогтолцоог хэвшүүлж, цаашид энэ зарчмыг баримтлан ажиллах болно.



Засгийн газар төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс ихгүй байхаар тогтоох шийдвэрийг гарган мөрдүүлж байна. Төрийн өмчит компаниудын гүйцэтгэх удирдлагатай ажлын хариуцлагыг сайжруулах үүднээс хөлсөөр ажиллах гэрээний хугацааг 6 сараар сунгаж, ажлын хариуцлага алдсан зарим захиралд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажлыг дүгнэх, компанийн засаглалыг сайжруулахад мэдлэгтэй, шинэ, санал санаачилгатай хамгийн шилдэг багийг тогтвортой ажиллуулах, хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлага байна.

Ил тод байдлыг компанийн дотоод болон гадна хүрээнд бий болгож, Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсыг нээн ажиллуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 41 дүгээр тэмдэглэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллах, 2016 оны зорилтот төвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх, компаниудын удирдлагын цалин хөлс, урамшууллын хэмжээг зохистой төвшинд хүргэж бууруулах үүрэг даалгавар өгсөн.

Энэ хүрээнд төрийн өмчит компаниудын гүйцэтгэх захирал болон удирдлагын цалин хөлс, урамшууллын хэмжээг өөрчилж, 30-60 хувиар бууруулах гэж заасны дагуу эдгээр шатлалд хамрагдаж байгаа хуулийн этгээдийн удирдлагын цалинг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 10.0 сая төгрөгөөс дээш цалинтай захирлуудын цалинг 2-2.5 дахин бууруулсан. Ингэснээр зөвхөн захирал, удирдлагуудын цалингаас жилд 1 тэрбум төгрөг хэмнэх бүрдэв.

Нөгөөтэйгүүр, 2016 онд зарцуулаагүй цалин хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд хогшил, эхлээгүй ажил үйлчилгээний зардлыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа. Өнгөрсөн 2016 онд эдгээр тэвчиж болохуйц хөрөнгө оруулалтын зардлаас 32.7 тэрбум төгрөг хэмнэсэн байна.

-----ooOoo-----